

**МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН
2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙСЭН ТАЛААРХ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 10 дугаар сарын 04, 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бүх Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 207 дугаар захирамжаар 2025 оны төсвийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан бөгөөд уг ажлын хэсгээс төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хүрээнд дэд ажлын хэсгүүдийг байгуулан саналуудыг нэгтгэн хэлэлцлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэхтэй холбогдуулан Улсын Их Хурлын бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо төсвийн төслийг хэлэлцээд зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, Төсвийн болон бусад Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд Төсвийн ажлын хэсэг болон Төсвийн байнгын хорооноос Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд доорх зохицуулалт хийх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Үүнд:

1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн зардлын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц дотор зардлын зориулалт өөрчлөх;

2.Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зардал шилжүүлэх;

3.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадлыг өөрчлөх саналуудыг гаргасан болно.

Мөн төсвийн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тусгасан 1 дүгээр хавсралтад тусгагдсан хөтөлбөрийн нэр өөрчлөх зэрэг болно.


Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.9 дэх хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хороо төсвийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг, бусад Байнгын хороо, түүнчлэн Төсвийн байнгын хорооны гишүүдийн гаргасан санал нэг бүрийг хэлэлцэн санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ДАВААСҮРЭН